

# ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2024 ОН

Улаанбаатар хот  
2025 оны 02 сарын 08

# ИЗНН үйл ажиллагааны тайлан 2024

Өнгөрсөн 2024 он ИЗНН-ын хувьд дотоод бүтэц, зохион байгуулалтдаа өөрчлөлт, шинэчлэлт хийсэн, гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, шинэ түвшинд гаргасан, намын үнэт зүйл, үзэл баримтлалаа тодотгон УИХ болон орон нутгийн сонгуульд амжилттай оролцсон амжилт бүтээлээр дүүрэн жил байлаа.

## Үнэт зүйл, үзэл баримтлал,

- Намын үнэт зүйл, үзэл баримтлалаа тодотгож, мөрийн хөтөлбөрийн дэлгэрэнгүй тайлбар ном хэвлүүлэн гишүүд, дэмжигчдийн гарт хүргэв.
- Мөрийн хөтөлбөрөө удирдлага болгон УИХ болон орон нутгийн сонгуульд урьд өмнөхөөс хамгийн олон нэр дэвшигчидтэй өргөн хүрээтэй оролцож, УИХ-д 4 гишүүнтэй, сумын ИТХ-д 4 төлөөлөгчтэй болсон амжилтанд хүрлээ.

# Бүтэц, зохион байгуулалт

1. Намын салбар нэгж байгуулагуудыг шинэчлэн зохион байгуулж, зарим аймаг, дүүрэгт шинээр Намын хороо байгуулан, үйл ажиллагааг нь тогтворжуулах ажлыг эхлүүлэн гишүүд, дэмжигчдээ нэмэгдүүлж эхэллээ.

5 дугаар сард намын удирдлага, ахмад, залуу идэвхитэй гишүүдийн төлөөлөл баруун болон зүүн аймгуудаар томилолтоор ажиллаж, аймгуудын Намын хороодод бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг дэмжиж ажиллахын зэрэгцээ орон нутгийн намын гишүүдийг сургалтанд хамруулж, мэдээлэл, зөвлөмжөөр хангалаа.

# Бүтэц, зохион байгуулалт

2. Улс Төрийн Зөвлөлөөс намын ХЭГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн баталлаа.

- Шинэ brand book хэвлэгдэж, намын өдөр тутмын ажилд ашиглагдаж эхэлсэн.
- ХЭГ-ын Хөдөлмөрийн дотоод журам шинээр боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөж эхэллээ.
- Албан хэрэг хөтлөлтийн журам шинээр боловсруулан баталж, намын бүх салбар нэгжийн хүрээнд баримт бичгийн стандартыг нэг мөр болгон хэрэгжүүлж байна.
- ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх журам шинээр боловсруулан батлуулсан.

# Гадаад хамтын ажиллагаа

Намын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, шинэ түвшинд гаргалаа. Үүнд:

- 11 сарын 27-нд БНКазахстан улсаас зохион байгуулсан “Арал-2024” бүс нутгийн дээд хэмжээний чуулга уулзалтанд намын удирдлагын төлөөлөл оролцлоо.
- 11 сарын 29-нд Чили улсын Сантьяга хотод болсон Либерал Интернэйшнл Холбооны 64 дүгээр Их хуралд оролцож, намын дарга Б. Батбаатар орон тооны бус дэд еөрөнхийлөгчөөр сонгогдлоо.
- 12 сарын 08-д БНХАУ-ын Бээжин хот, Жянши мужийн Наньчан, Жюжан хотуудад намын удирдлагууд албан ёсоор айлчилж, ногоон хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтийн туршлагатай танилцлаа.
- 12 сарын 16-нд намын дарга Б. Батбаатар БНСУ-д айлчилж, “Эрх чөлөөний холбоо” НҮБ-ын эдийн засаг, нийгмийн Зөвлөлийн дэргэдэх тусгай консулын статустай ТББ-тай хамтран ажиллах тохиролцоонд хүрлээ.

## Дэргэдэх байгууллагууд

Намын дэргэдэх байгууллагуудын үйл ажиллагаа идэвхижиж эхэллээ. Үүнд:

- 2 сарын 23-нд намын залуу гишүүдийг сургалтанд хамрууллаа.
- Иргэний зориг Эмэгтэйчүүдийн холбооний гишүүд хэд хэдэн удаа цуглан хуралдаж, хэлэлцүүлэг зохион байгуулж, холбооны дүрмээ баталж, үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлж эхэллээ.
- Намын ахмад гишүүд дэмжигчид мөн үйл ажиллагаагаа идэвхижүүлж, Иргэний зориг Ахмадын холбооны бүтэц, зохион байгуулалтаа шинэчиллээ.

# Намын гишүүдэд чиглэсэн үйл ажиллагаа

Намын гишүүдийг идэвхижүүлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдэд зохион байгуулсан ажил:

- 2 сарын 14-нд Цагаан сар, 10 сарын 2-нд Ахмадын баяраар намын ахмад гишүүдээ хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.
- 3 сарын 9-нд Намын 24 жилийн ойн баяраа тэмдэглэлээ.
- 7 сарын 11-д Үндэсний их баяр наадмаар “Хүй 7 худаг”-т отог байгуулж, намын гишүүд, дэмжигчидээ хүлээн авлаа.
- 12 сарын 20-нд намын “Шинэ жил”-ийн баярыг Иргэний Зориг Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгууллаа.

# Намын гишүүдэд чиглэсэн үйл ажиллагаа

2. Олон нийтийг хамарсан бусад ажил:

- 5 сарын 13-нд уламжлалын дагуу “Мод тарих” өдөр зохион байгууллаа.
- 12 сарын 7-нд Спортын 5 төрөлт тэмцээн

## ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Намын албан ёсны вебсайт, пейж хуудсаа шинэчилж, намын үйл ажиллагааны талаар гишүүд, дэмжигчид, иргэдэд тогтмол мэдээлэл хүргэж эхэлсэний үр дүнд намын пейж хуудсын дагагчид арван мянга гаруйгаар нэмэгдэж, арван гурван мянгад хүрлээ.
- 500 орчим фото болон видео мэдээ, 20 гаруй нэвтрүүлэг бэлтгэжээ.
- “Иргэний зоригийнхон юу хийдэг вэ?” цуврал контент гаргаж эхлэн өнөөдөр нийт 20 гаруй цуврал гараад байна.